

БАТЛАВ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАЛЖИННЯМ

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК



Огноо: 2020.05.04



**ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: ДҮТ-2020-04-28

Тендер шалгаруулалтын дугаар: ДҮТ/202001028

Улаанбаатар

2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ” ТӨВ ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Интернетийн үйлчилгээ худалдан авах” тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <https://tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 5 сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд* ирүүлнэ.

Үнийн саналыг 2020 оны 5 сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Тендерийн нээлтэд сонирхсон этгээд оролцох эрхтэй бөгөөд тендерт оролцогч системд нэвтрэн орж тендерийн нээлттэй танилцах эрхтэй.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: *Эрхгүй*

Дотоодын давуу эрх тооцох эсэх: *Тооцохгүй.*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

<https://tender.gov.mn>

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br><br>(а) Үнийн санал;<br><br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br><br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>Үүнд:<br>✓ Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайланг баталгаажуулж ирүүлэх<br>✓ Борлуулалтын орлого сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жил тухайн тендерийн төсөвт өртгөөс багагүй байх<br>✓ Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2018, 2019 он гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн (гэрээ дүгнэсэн) акт/<br><br>(г) Интернетийн үйлчилгээ эрхлэх “Б” ангилалын тусгай зөвшөөрөлтэй байх. /Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болоогүй байх/;<br><br>(д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг доор жагсаав. Үүнд:<br>✓ Компанийн дэлгэрэнгүй танилцуулга<br>✓ Улсын гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/<br>✓ Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./<br>✓ ШШГЕГ-ын тодорхойлолт<br>✓ Гэрээний үнэ, хугацаанд нийлүүлэх, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл<br><br>✓ Бараа нийлүүлэлт, үйлчилгээний хуваарь<br>✓ Ажиллах хүчний буюу хүний нөөцийн мэдээлэл<br>✓ Холболтын шийдэл, дамжуулалтын зураг, схем ирүүлэх; |

- |  |   |
|--|---|
| 4. Тогтмол үнэ                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрт заавал үнийн санал ирүүлнэ.<br><br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайланг баталгаажуулж ирүүлэх</li> <li>2. Борлуулалтын орлого сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жил тухайн тендерийн төсөвт өртгөөс багагүй байх</li> <li>3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2018, 2019 он гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн (гэрээ дүгнэсэн) акт, протокол/</li> <li>4. Интернетийн үйлчилгээ эрхлэх “Б” ангилалын тусгай зөвшөөрөлтэй байх. /Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусгавар болоогүй байх/;</li> </ol> <p>Бусад нэмэлт шаардлага</p> <ol style="list-style-type: none"> <li>5. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</li> <li>6. Улсын гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/</li> <li>7. Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./</li> <li>8. ШШГЕГ-ын тодорхойлолт</li> <li>9. Гэрээний үнэ, хугацаанд нийлүүлэх, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл</li> <li>10. Бараа нийлүүлэлт, үйлчилгээний хуваарь</li> <li>11. Ажиллах хүчний буюу хүний нөөцийн мэдээлэл</li> <li>12. Холболтын шийдэл, дамжуулалтын зураг, схем ирүүлэх;</li> <li>13. Бусад шаардлагатай материалууд /тоног төхөөрөмжийн фото зураг, танилцуулга, техникийн үзүүлэлтүүд гэх мэт/</li> </ol> <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн бичиг баримтыг тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн дарааллын дагуу хавсаргаж ирүүлнэ үү.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг Тендер нь Цахим тендер шалгаруулалт журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /<a href="https://tender.gov.mn/">https://tender.gov.mn/</a>-д өөрийн аж ахуйн нэгжийн нууцлалын кодоор нэвтрэн орж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Холбоо барих утас: 70041371-444 Ц.Ганзориг</p>
	<p>Огноо: <i>2020 оны 5 сарын 12 өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> <p><i>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</i></p>
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:

	<p><i>Монгол улс, Улаанбаатар хот , Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн үндэсний төв ХХК” 5-р давхар 515 тоот өрөө</i></p> <p><i>Огноо: 2020 оны 5 сарын 12 өдөр</i></p> <p><i>Цаг: 10 цаг 30 минут</i></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b><i>Байхгүй.</i></b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ий интернэтийн үйлчилгээний техникийн шаардлага

Интернэтийн үйлчилгээг үзүүлэгч байгууллага нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- Интернэтийн гадаад урсгал нь DOWNLOAD/UPLOAD хурд 40 mbps болон түүнээс дээш хурдтай байх
- Dedicated буюу шууд шилэн кабелийн стандартын дагуу холболттой байх
- Олон улсын давхар гарцтай
- Өөрийн мэдлийн IP нэрийн сервертэй /DNS/ -тэй байх
- Гадаад болон дотоод урсгал нь 2 тусдаа шилэн кабелийн шөрмөсөөр байх /гадаад урсгалд лимит хийхэд дотоод урсгал хязгаарлагдахгүй байх/
- IP хаягжилт нь дараалласан 64 хаяг бүхий гадаад IPv4 хаяг байх
- Монгол улс дотор байршуулсан вэб хуудсуудад хурдны хязгааргүй ханддаг байх
- Интернэтийн үйлчилгээг зогсоох, таслах зэрэг үйлдэл хийхээс 24-48 цагийн өмнө урьдчилан албан бичиг болон цахим шуудангаар мэдэгддэг байх
- 24 цагийн техник үйлчилгээний ажилтантай байх, оператор үйлчилгээгээр дамждаггүй байх
- 24 цагийн автоматжуулсан мониторинг, хяналтын системтэй байх
- Олон улсын стандартад нийцсэн нууцлал хамгаалалтын системтэй байх
- Гаднаас ирэх халдлагаас хамгаалах хамгаалалтын системтэй байх
- Нөөц холболт хийх боломжтой байх - Редундант /Төмөр замын дохиолол холбооны 2-р ангитай холбогдох/
- Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэжлийн инженерийн зөвөлгөө, тусламж өгдөг, хамтран ажилладаг байх

Байгууллагад зориулсан нэмэлт үйлчилгээ урамшуулал нь давуу тал болно

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкогермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Интернетийн үйлчилгээ	3-р бүлэгт тусгагдсан техникийн тодорхойлолтын дагуу	1	ширхэг	ДҮТ ХХК-ийн байр /Засгийн газрын ХҮ байр/	Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног	Гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоног	



**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**ДҮТ ХХК-н гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО

### ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[ГТН-д заасан]</i> жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай  |

тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- |  |   |
|--|---|
| <b>10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах</b> | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                    | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.              |

### Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Барааг хүлээлгэн өгөхдөө холбогдох эрх бүхий албан тушаалтанд бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгуулж, зөвшөөрлийг авсан байна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) үйлдвэрлэгчийн буюу н ийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>4) барааны гарал үүслийн гэрчилгээ. |

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар  
(ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
4. Төлбөр  
(ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт, мөн гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг болон санхүүгийн баримт, бараа хүлээж авсан актыг үндэслэн төлнө.**
- Гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлж буй бараа бүрэн ажиллагаатай эсэхэд үндэслэн гэрээний төлбөрийг урьдчилгаа төлбөрийн нөхцөлгүйгээр барааг бүрэн хүлээлгэж өгсний дараа нийлүүлэгчид төлнө.
5. Алданги оногдуулах  
(ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05**
- Алдангийн нийт дүн: **10%**

---

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.